

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

2024 оны 6 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас
шүүхийн шийдвэрийг хянуулах тухай

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.07.01-ний өдрийн 128/ШШ2020/0453 дугаар шийдвэр, Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2021.01.25-ны өдрийн 32 дугаар шүүх хуралдааны тогтоолтой, "Тальн гал" ХК-ийн нэхэмжлэлтэй, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргад холбогдох Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5-д заасныг баримтлан Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Геологи, уул уурхайн Кадастрын газрын даргын /хуучин нэрээр/ 2008 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 1396 дугаар шийдвэрийн "Энгүй тал" ХХК-д холбогдох хэсгийг захиргааны байгууллагаас дахин шинэ акт гартал 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, шүүхээс тогтоосон хугацаанд хариуцагч байгууллагаас шинэ акт гаргаагүй бол маргаан бүхий захиргааны актын "Энгүй тал" ХХК-д холбогдох хэсэг нь хүчингүй болохыг дурдаж шийдвэрлэсэн захиргааны хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулахаар энэхүү хүсэлтийг гаргаж байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсгийн 131.1.1-д *"шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй болон мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрсэн"* бол хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэхээр хуульчлан заасан.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.07.01-ний өдрийн 128/ШШ2020/0453 дугаар шийдвэрийн үндэслэх хэсэгт: "... "Энгүй тал" ХХК-иас 2008 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр гаргасан ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг хариуцагч захиргааны байгууллага хүлээн авч 22073 кодоод бүртгэхдээ "хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээж авсан Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэр"-ийг хавсаргаж өгсөн гэж тэмдэглэсэн боловч энэ нь Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 9-1 дугаар бүхий, "Онгон-Улаан уулын алтны шороон ордод 2003-2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн тухай" баримт байсан болох нь тогтоогдож байна..." гэж,

Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2021.01.25-ны өдрийн 32 дугаар шүүх хуралдааны тогтоолд: "19. Нөгөөтэйгүүр, анхан шатны шүүхийн "... "Энгүй тал" ХХК нь 14209А дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлж авсан үйл баримт тогтоогдсон, ... хариуцагч байгууллагаас үүнийг хүлээн зөвшөөрч "Энгүй тал" ХХК-д тусгай зөвшөөрлийг цуцлах талаар мэдэгдэл хүргүүлсэн атлаа уг мэдэгдлийн дагуу ямар үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдохгүй ..." гэсэн дүгнэлт үндэстэй.

20. Учир нь Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5-д заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай гол баримт болох “хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж хүлээж авсан Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэр” нь энэ “Тал булаг” нэртэй талбайд хийгдсэн хайгуулын ажлын үр дүнг хэлэлцэж хүлээн авсан тэмдэглэл, шийдвэр биш байгаа тул хуульд заасан дээрх шаардлагыг хангаагүй нөхцөлд уг талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноор нэхэмжлэгч хуулийн этгээдийн ашигт малтмал ашиглах, түүнтэй холбогдсон газар ашиглах эрх зөрчигдсөн байдлыг арилгах замаар захиргааны байгууллагаас дахин шинэ акт гартал 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж шийдвэрлэсэн нь зөв байна” гэж тус тус дүгнэлтийг хийсэн байна.

Мөн Монгол Улсын дээд шүүхийн Хяналтын шатны шүүх хуралдааны 2021.01.25-ны өдрийн 32 дугаар тэмдэглэлд: “22. Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Жанчив: Хавтас хэрэгт С-02 гэсэн тэмдэглэл авагдсан. Харин С-01 гэсэн тэмдэглэл авагдаагүй” гэсэн, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн шүүх хуралдааны тэмдэглэлийн 6 дугаар талд: “...Нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс: ... “Энгүй тал” ХХК нь өргөдлөөр тусгай зөвшөөрөл авахдаа хайгуулын тайлангаа гаргаж өгөх ёстой. Гэтэл Баянхонгор аймгийн нутагт орших алтны уурхайн хайгуулын Эрдэс, баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг гаргаж өгсөн байдаг. Хууран мэхлэх замаар тусгай зөвшөөрлийг авсан нь тогтоогдож байгаа. Мөн гуравдагч этгээд маань хайгуулын ажил хийсэн гэж ярьдаг боловч тухайн талбайд ямар нэгэн хайгуулын ажил хийгдээгүй ...” гэж шүүх хуралдаанд тайлбарлаж байсан байна.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.07.01-ний өдрийн 128/ЛШП2020/0453 дугаар шийдвэр, Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2021.01.25-ны өдрийн 32 дугаар шүүх хуралдааны тогтоолтой, “Талын гал” ХК-ийн нэхэмжлэлтэй, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргад холбогдох захиргааны хэрэгт Үйлдвэр, худалдааны яам, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн С-2-2 дугаар дүгнэлт буюу захиргааны байгууллагын шийдвэр нь нотлох баримтаар авагдсан бөгөөд гагцхүү шүүхэд энэ шийдвэрийн үндэс болсон “Талбулаг-1” лицензтэй талбайд 2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайланг өгөөгүй, түүний оронд “Онгон-Улаан” уулын алтны шороон ордод 2003-2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хариуцагчийн зүгээс гарган өгсөн байдаг.

“Энгүй тал” ХХК нь Үндэсний Геологийн албаны геологийн баримтын төв архиваас 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр өөрийн компанийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дахь “Талбулаг-1” лицензтэй талбайд 2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлангийн хуулбар хувь /29 нүүр хуудас/-ийг гаргуулан авсан.

Уг тайланг 2008 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр АМГТХЭГ-ын Геологийн газрын мэргэжилтэн Б.Энхтуяа, Ц.Уранцэцэг нарт танилцуулагдан, мөн Улсын Мэргэжлийн Хяналтын Газрын БОГУУУХА-ын байцаагч Л.Цэвэрравдан хянан, мөн Геологийн газар хянаж тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

Энэ тайлан нь Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.07.01-ний өдрийн 128/ЛШП2020/0453 дугаар шийдвэртэй хэргийг шийдвэрлэж байхад тухайн хэргийн хариуцагч байгууллагад хадгалагдаж байсан гэж үзэж байсан бөгөөд тухай үеийн төлөөлөгчийн зүгээс тайланг хайж олж өгөлгүй, өөр хайгуулын

ажлын тайланг шүүхэд гаргаж өгсөн байна. Тухайн үед Ашигт малтмалын газрын 2015 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 6/4196 дугаар Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгч А.Сарангэрэлд хаягласан албан бичигт “Энгүй тал” ХХК нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргахдаа ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргасан бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д заасан заалтыг хангаж байсан байна” гэж тайлбарыг хүргүүлж байсан байна.

2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын Агентлаг байгуулах тухай 230 дугаар тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба байгуулагдсан байна. Хэргийг шийдвэрлэх үе нь энэ Үндэсний геологийн албаны геологийн баримтын архив байгуулагдсантай ойролцоо бөгөөд тухайн хэрэг маргаанд оролцож байсан хариуцагч байгууллагын төлөөлөгч шүүхэд тайланг олж гаргаж өгч чадаагүй нь архивт баримтуудыг шилжүүлж байсантай холбоотой байсан юм болов уу гэж үзэж байна.

Иймд тухайн хэрэг шийдвэрлэгдэх үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй байсан “Энгүй тал” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дахь “Талбулаг-1” лицензтэй талбайд 2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлан илэрсэн тул Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.07.01-ний өдрийн 128/ШШ2020/0453 дугаар шийдвэр, Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2021.01.25-ны өдрийн 32 дугаар шүүх хуралдааны тогтоолтой, “Талын гал” ХК-ийн нэхэмжлэлтэй, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргад холбогдох захиргааны хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянаж өгнө үү.

“Энгүй тал” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дахь “Талбулаг-1” лицензтэй талбайд 2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайланг хавсаргав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



[Handwritten signature]

Э.БОЛОРТУЯА